



хөгжүүлэх ёстой. Эдгээр нь гагцхүү дижитал эдийн засгийн хөгжилд тулгуурлана гэж дүгнэжээ. Шинэ эдийн засгийн бүтэц, онцлог шинжийг ийнхүү тодорхойлох нь онол, арга зүйн хувьд төдийгүй практикийн их ач холбогдолтой юм. Монгол Улс шинэ эдийн засгийг хөгжүүлэхийн тулд тэдгээрийн бүрэлдэхүүн хэсгүүдийг харилцан уялдаатай, нэгдмэл байдлаар бүрдүүлэх шаардлагатай. Шинэ эдийн засаг эдийн засгийн хөгжлийг хурдасгах нь тодорхой боловч хүн амын амьжиргааг хэрхэн сайжруулах, ялангуяа ядуурлыг хэр зэрэг бууруулах, нийгмийн салбаруудын хөгжилд хэрхэн нөлөөлөх нь хараахан тодорхой бус байна. Түүнчлэн дэлхий улс төр, эдийн засгийн нөхцөл байдал эрс өөрчлөгдлөө. Ийм шинэ нөхцөлд шинэ эдийн засгийн хөгжлийн хандлага, үр нөлөө, үр дагавар зэргийг шинэ улс төрийн эдийн засгийн ухаан хийх боломжтой гэдгийг зохиогч хэд хэдэн зүйлээр үндэслэсэн байна.

**Түлхүүр үгс:** шинэ улс төрийн эдийн засгийн ухаан, мэдлэгийн ба дижитал эдийн засаг

and methodological significance, but also practical value. So, in order to develop a new economy, Mongolia must form its constituent parts in an interconnected and holistic way. The new economy will certainly accelerate economic development, but it is not yet clear how it will improve the lives of the population and in particular reduce poverty and how it will affect the development of social sectors.

Along with this, the political and economic situation in the world has changed significantly. In such a new environment, it is necessary to carefully study the trend and consequences of the new economy, as well as the contradictions in international relations and the development of the country.

The author believes that this problem may well be solved by the new political economy and substantiates his conclusion with some arguments.

**Keywords:** new political economy, knowledge economy, digital economy

## I. Оршил ба судалгааны арга зүй

XX зууны эцэс, XXI зууны эхээр хувийн компьютер, интернет бий болж, дэлхийн өнцөг булан бүрт байгаа хүмүүс хоорондоо шууд холбогдох болсон нь аж үйлдвэрийн гуравдугаар хувьсгалын эхлэл байлаа. Энэ нь үйлдвэрлэл, үйлчилгээний үйл явцыг тоон технологид шилжүүлэх боломжийг олгож, түүнийг иж бүрэн автоматжуулахад хүргэв. Робот техник бий болж, хүний олон үйл ажиллагааг орлох боллоо.

Аж үйлдвэрийн II ба III хувьсгал нүүрстөрөгчийн эрчим хүчийг ашиглан хөгжсөн бол цаашид түүний үлэмж их хэрэглээ хүн төрөлхтөний оршин байхад аюул занал учруулах хэмжээнд хүрчээ. Иймд эрчим хүчний шинэ эх үүсвэрийг хайх болов. Нар, салхи, ус, биомасс, газрын гүний дулаан ашиглан эрчим хүч үйлдвэрлэх олон сая жижиг нэгжүүдийг байгуулж, тэдгээрийг интернет харилцааны зарчмаар хооронд нь холбож, улмаар өөрийн хэрэгцээнээс илүү гарсан эрчим хүчээ бусадтай хуваалцах хялбар, шуурхай сүлжээг үүсгэх боломжтой гэж үзэж байна[1]. Нүүрстөрөгчөөс устөрөгчид шилжих нь эрчим хүчний хувьсгалын гол зорилт болжээ. Энэ нь хуучин эдийн засгаас шинэ эдийн засагт шилжих шилжилтийн нэг гол чиглэл юм.

Аж үйлдвэрийн III хувьсгал эхлээд удаагүй байхад IV хувьсгал өрнөж эхэлсэн бөгөөд хиймэл оюун ухаан, үүлэн тооцоолох систем, өндөр хурдны интернет, блокчейн сүлжээ, виртуаль бодит байдал зэрэг шинэ дижитал

технологи үүсэж, улмаар шинэ эдийн засаг бүрэлдэж эхэллээ. Энэ нь нийгмийн харилцааг хэрхэн өөрчлөх, хүн амын амьдралд ямар нөлөө үзүүлэх, хүн төрөлхтөний ирээдүйг яаж өөрчлөх, энэ хувьсгалд эцэс төгсгөл бий эсэх талаар судлах нэн шаардлагатай бөгөөд үүнийг шинэ улс төрийн эдийн засгийн ухаан хийх ёстой. Бид энэ өгүүлэлд шинэ эдийн засгийг шинэ улс төрийн эдийн засгийн ухаанаар судлах асуудлыг хөндөх болно.

Ингэхдээ улс төрийн эдийн засгийн ухааны **судалгааны гол арга болох задлан шинжлэх ба нэгтгэн дүгнэх, индукц ба дедукцийн аргыг** голлон хэрэглэв. Тухайлбал, шинэ эдийн засгийг судлахын тулд түүнийг бүрдүүлэгч хэсгүүдийг тус тусад нь задлан шинжилж, дараа нь тэдгээрийн хоорондын уялдаа холбоог тогтоох, нэг систем болохынх нь хувьд тодорхойлов. Мөн дижитал эдийн засгийн мөн чанар онцлогийг харуулахын тулд түүний бүтцийн элементүүдийн онцлог болон харилцан хамаарлыг тогтоох оролдлого хийв. Шинэ эдийн засгийг шинэ улс төрийн эдийн засгийн ухаан судлах шаардлагатай болохыг түүхэн ба логик аргыг хослуулах үндсэн дээр нотлохыг хичээв.

## **II. Шинэ эдийн засаг ба түүний бүтэц**

Шинэ эдийн засгийн шинж чанарыг тодорхойлж академич Т.Дорж бичихдээ “Тэрчлэн юм бүхэн түргэн хувьсан өөрчлөгдөж, технологиуд, бизнесийн санаанууд ч, мэргэшил ч амархан хуучирч, эдийн засгийн бүх салаа мөчирт цахилгаан теле-харилцааны систем, мэдээлэл холбооны технологи, ухаалаг төхөөрөмж, их өгөгдөл, программ хангамж, юуны түрүүнд, интернетийн сүлжээ хүчээр түрэн орж магадгүй болоод байна. Энэ бүхнийг өдгөө шинэ эдийн засаг (new economy) гэж нэрлэх болж байна... “Шинэ эдийн засаг”-ийн хүчин зүйлсийн анхны бөгөөд нэн чухал нь оюун ухаан ба мэдлэг юм. Бусад хоёр хүчин зүйл нь (хувирал өөрчлөлт, даяаршил – Б.Б.) оюун ухааны капиталын ач холбогдлыг гагцхүү өндөржүүлж байгаа ч, үүнд бас бие даасан учир утга байгаа юм.”[2] гэжээ.

Аж үйлдвэрийн IV хувьсгалын үр дүнд үүсэж буй шинэ эдийн засаг нь дараах онцлогтой. Үүнд, нэгд, шинэ эдийн засаг бол мэдлэг ихээр шингээсэн, өөрөөр хэлбэл, шинжлэх ухаан, технологийн хөгжил, инновацид тулгуурласан эдийн засаг юм. Мэдлэгийн эдийн засаг оюуны капиталыг илүүтэй ашигладгаараа онцлог юм. Энэ нь байгалийн нөөц, эд юмсын орцыг биш, харин инновацийг төрүүлэгч хүний мэдлэгийг голлодог эдийн засаг юм.


Хоёрт, шинэ эдийн засаг шинжлэх ухаан, технологийн хөгжил, инновацид тулгуурласан эдийн засаг юм. Энэ нь их өгөгдөл, квантын технологи, блокчейн, эд юмсын интернет сүлжээ, үүлэн тооцоолох систем, хиймэл оюун, робот техник, автоматжуулалт, 3D хэвлэлт, дамжуулагчгүй хурдны технологи, виртуаль бодит байдлын технологи зэрэг дижитал технологи бүхий эдийн засаг юм.

Гуравт, шинэ эдийн засаг нь байгаль орчныг хамгаалах, дэлхийн дулаарлыг зогсоох, үүний тулд сэргээгдэх эрчим хүчийг ашиглах, байгалийн материал, түүхий эдийг ариг гамтай хэрэглэх, хог хаягдлыг багасгахад чиглэсэн ногоон эдийн засаг юм. Энэ нь эдийн засаг, нийгэм, байгаль орчны харилцан зохистой хөгжлийг хангах эдийн засаг юм.

Дөрөвт, шинэ эдийн засаг нь хаягдалгүй эдийн засаг болон хувирч байна. Энэ нь үйлдвэрлэл, хэрэглээнээс гарсан, хуучирч муудсан зүйлсийг урьдын адил байгаль орчинд хаяхгүй, харин дахин боловсруулж ашиглах, өөрөөр хэлбэл, үйлдвэрлэлийн нийт мөчлөгийг боловсруулалтын тасралтгүй үйл явц болгоход чиглэсэн эргэлтийн эдийн засаг юм.

Тавд, байгаа нөөцийг аль болохоор бүрэн дүүрэн ашиглах, илүү зардлыг хэмнэх, тодруулж хэлбэл, эд баялаг, мэдлэг, ур чадварыг сул, ашиглалтгүй орхихгүй, харин хамтран ашиглаж, эдийн засаг, нийгмийн үр ашгийг дээд зэрэгт хүргэх гэсэн эдийн засаг юм. Үүнийг бусадтай хуваалцах эдийн засаг гэж нэрлэж болно.

Зураг 1. Шинэ эдийн засгийн бүтэц



Шинэ эдийн засгийн бүрэлдэхүүн хэсгүүдийг товч авч үзье.

**Мэдлэгийн эдийн засаг.** Шинэ эдийн засгийн гол эх сурвалж бол **мэдлэгийн эдийн засаг** юм. Энэ нь мэдлэг буюу оюуны капиталыг голлон ашиглах үндсэн дээр бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлчилгээ үзүүлэх, хэрэглэх систем юм. Өөрөөр хэлбэл, мэдлэгийн эдийн засаг нь шинжлэх ухааны нээлт, ололт болон судалгааны үр дүнг практикт ашиглан, бүтээгдэхүүн, үйлчилгээг шинэчлэх, загвар, чанар, үзүүлэлтийг сайжруулахад чиглэгдэнэ. Шинэ эдийн засаг бол мэдлэг ихээр шингээсэн, өөрөөр хэлбэл, шинжлэх ухаан, технологийн хөгжил, инновацид тулгуурласан эдийн засаг юм.

Мэдлэгийн эдийн засаг дараах онцлогтой. Нэгд, хэрэв хуучин эдийн засаг байгалийн нөөц ба ажиллах хүчний тоог нэмэгдүүлэх замаа үйлдвэрлэлийг өргөтгөж, нийт бүтээгдэхүүний өсөлтийг хангахыг зорьдог бол мэдлэгийн эдийн засаг нь шинэ мэдлэгийг үйлдвэрлэлийн гол хүчин зүйл болгон ашиглаж, бүтээмжийг дээшлүүлэн, бага орцоор их бүтээгдэхүүн үйлдвэрлэх, тэгэхдээ шинэ бүтээгдэхүүн хийхийг чухалчилна. Өөрөөр хэлбэл, хуучин эдийн засгийн нөхцөлд үйлдвэрлэлд 1) техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл буюу хөдөлмөрийн хэрэгсэл, 2) түүхий эд, материал буюу хөдөлмөрийн зүйл, 3) ажиллах хүч гэсэн гурван гол орц оролцдог бол мэдлэгийн эдийн засгийн хүрээнд үйлдвэрлэлд энэ гурваас гадна мэдлэг гэсэн шинэ орц орно.

Хоёрт, хэрэв хуучин эдийн засагт ажиллагчдын боловсрол, мэдлэг чухал биш, тэдний гар хөдөлмөр хэрэгтэй бол мэдлэгийн эдийн засгийн гол хөдөлгөгч

хүч нь өндөр боловсрол, ур чадвартай ажиллагчид юм. Өндөр боловсрол, ур чадвартай ажиллагчид компьютерийг сайн эзэмшсэн, өгөгдөл боловсруулах, программ, алгоритм, загварчлалыг унших, хөгжүүлэх, инновац сэдэх чадвартай байдаг.

Гуравт, шинэ мэдлэг бий болгох нь үйлдвэрлэлийн шинэ салбар болон хөгжиж байна. Томоохон компаниуд хажуудаа эрдэм шинжилгээ-туршилтын институт, баазтай болж, шинэ мэдлэг боловсруулах ажлыг дагнан гүйцэтгүүлэх болжээ. Ингэхдээ үйлдвэрлэлд нэвтрүүлэх зорилготой тусгайлсан мэдлэгийг бий болгох зорилгыг тавьж хэрэгжүүлж байна.

Дөрөвт, мэдлэгийн эдийн засаг нь мэдээлэл, харилцааны шинэ технологид суурилж байна. Тавд, хуучин эдийн засагт нөөцийн хомсдол байнга үүсдэг бол мэдлэгийн эдийн засгийн гол хүчин зүйл болох шинэ мэдлэгийн нөөц шавхагдашгүй юм. Зургаад, хуучин эдийн засагт газар зүйн байршил чухал ач холбогдолтой байсан бол мэдлэгийн эдийн засагт газар зүйн аливаа хязгаарлалт үгүй болж, хил хязгааргүй хөгжих боломжийг олгож байна.

Мэдлэгийн эдийн засгийг зохион байгуулалттай хөгжүүлж буйн жишээнд АНУ-ын Цахиурын хөндий орох бөгөөд аз сорьсон, эрсдэл үүрсэн гарааны компаниуд эндээс ажлаа эхэлж амжилтад хүрсэн. 2020 оны байдлаар ийм 117 компаний нээлттэй хувьцааны арилжаа 253 тэрбум ам.долларт хүрчээ. Технологийн бизнесээр хөрөнгөжсөн 143 тэрбумтан Цахиурын хөндийд амьдардаг ажээ[3].

*Дижитал эдийн засаг, түүний бүрэлдэхүүн хэсгүүд.* Шинэ эдийн засгийн гол хөдөлгөгч хүч нь дижитал эдийн засаг юм. Дижитал эдийн засаг гэж юу болох талаарх нэгдсэн тодорхойлолт хараахан бий болоогүй байна. Байгууллага, эрдэмтэд, мэргэжилтнүүд түүнийг янз бүрээр тодорхойлж байна. Тухайлбал, “Дижитал эдийн засаг бол дижитал тооцоолох технологид үндэслэсэн эдийн засаг бөгөөд дижитал бараа, үйлчилгээнд суурилсан бизнесийн ажиллагаа юм.”[4] гэж Манчестерийн их сургуулийн эрдэмтэн Р.Бухт, Р.Хикс нар бичжээ. Энэ хоёр эрдэмтэн дижитал эдийн засгийн талаарх тодорхойлолтуудыг судлан, аль нь ямар асуудлыг голлон тавьсныг дэлгэрэнгүй хүснэгтээр харьцуулан үзүүлсэн байна. Тухайлбал, “Дижитал эдийн засаг бол тоон технологид үндэслэсэн эдийн засаг бөгөөд гэхдээ бид үүнийг голчлон интернетийн сүлжээг ашиглан зах зээлүүд дээр явагдаж байгаа бизнесийн ажиллагаатай холбон үзэж байна”[5]хэмээн Их Британий компьютерийн нийгэмлэгийн илтгэлд дурджээ.

Дэлхийн банк “Дижитал эдийн засаг бол мэдлэг ба тоон технологид үндэслэгдсэн эдийн засгийн шинэ хэвшил бөгөөд түүний хүрээнд нийгэм, бизнес, төр шинэ тоон чадвар, боломжтой болдог”[6] хэмээн тодорхойлжээ. Австралийн Засгийн газар “Интернет болон хөдөлгөөнт, мэдрэгчийн сүлжээний тусламжтай явагдаж байгаа эдийн засаг, нийгмийн үйл ажиллагааны дэлхий дахины сүлжээ нь дижитал эдийн засгийг бүрдүүлнэ.”[7] гэжээ.

Москвагийн Эдийн засгийн дээд сургуулийн Үндэсний судалгааны их сургуулийн эрдэмтэд дижитал эдийн засгийн талаарх янз бүрийн ойлголт, байр суурийг судалсны үндсэн дээр “Дижитал эдийн засаг бол тоон технологи болон түүнтэй холбоотой бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгох, түгээн дэлгэрүүлэх, ашиглах талаарх үйл ажиллагаа юм. Тоон технологи бол өгөгдлүүдийг цахим

хэлбэрээр цуглуулах, хадгалах, боловсруулах, эрж хайх, илэрхийлэх технологи мөн”[8] гэж тодорхойлжээ.

Эдийн засгийн шинжлэх ухааны доктор Б.Баттөмөр шинэ эдийн засгийн чиглэлээр нэлээд ул суурьтай судалгаа хийж байгаа бөгөөд “Шинэ эдийн засаг” хэмээх номондоо “Дижитал эдийн засаг нь программ хангамжийг бүтээж, худалдан борлуулахаас эхлээд цахим бизнес, цахим худалдаагаар дамжуулан цахим бараа, үйлчилгээг цахим буюу дижитал мөнгөөр худалдаж, хүргэхтэй холбоотой бүх үйл ажиллагааг хамаарна. Үүнд төрийн оролцоо, зохицуулалт чухал үүрэгтэй. Дижитал эдийн засаг гэдэг бол мэдээлэл, харилцаа холбооны технологид суурилсан, дэлхийг хамарсан эдийн засгийн сүлжээ юм. Энгийнээр хэлбэл, дижитал технологид суурилсан эдийн засаг гэж ойлгож болно.”[9] гэжээ. Дээрх тодорхойлолтуудын аль нь ч дижитал эдийн засгийн агуулгыг бүрэн илэрхийлж чадахгүй, зөвхөн түүний бүрэлдэхүүний зарим нэг хэсгийг л тодотгож байна. Дижитал эдийн засаг нь олон төрлийн технологи, систем, аппарат хэрэгсэл, сүлжээнээс бүрдэнэ. Үүнд, 1) их өгөгдөл (Big Data), квантын технологи, 2) блокчейн, 3) эд юмсын интернет сүлжээ (Internet of Things), 4) үүлэн тооцоолох систем (Cloud Computing), 5) хиймэл оюун (Artificial Intelligence) 6) робот техник, автоматжуулалт, 7) 3D хэвлэлт, 8) дамжуулагчгүй хурдны технологи, 9) виртуаль бодит байдлын технологи (Virtual Reality), 10) байрлал илрүүлэх технологи (Location Detection) зэрэг болно. Дижитал эдийн засгийн бүрэлдэхүүн хэсгүүдийг Зураг 1-т дүрслэв. Эдгээрийг тус бүрд нь товч авч үзье.

Зураг 2. Дижитал эдийн засгийн бүрэлдэхүүн хэсгүүд



Их өгөгдөл гэдэг нь байнга нэмэгдэж, өөрчлөгдөж байдаг асар их системчилсэн болон системчлээгүй мэдээллийг цуглуулах, боловсруулах, системчлэх, хадгалах, эрж хайх технологи юм. Энэ нь квант технологи болон мэдээлэл, харилцааны технологид үндэслэгдэн үйлчилнэ. Их өгөгдлийн эх сурвалж нь нэгд, эд юмсын интернет, хэмжих багаж, радио долгионы төхөөрөмжийн мэдээлэл, хоёрт, олон нийтийн мэдээллийн сүлжээ, гуравт, цаг

агаарын болон дэлхийн төлөв байдлын ажиглалтын мэдээлэл, дөрөвт, хэрэглэгчийн байрлалын мэдээлэл, тавд, үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагын дотоод мэдээлэл гэх мэт болно.

Блокчейн нь хүмүүс хоорондоо ямар нэг зуучлагчгүйгээр мэдээлэл дамжуулах, гүйлгээ хийх тоон технологид суурилсан интернетийн сүлжээ юм. Энэ нь 1) блок буюу тодорхой мэдээлэл цуглуулж агуулсан багц, 2) багцуудыг хооронд нь математик аргаар үүсгэсэн нууц кодоор холбох гинж, 3) зангилаануудын хооронд хийгдсэн гүйлгээнүүдийн бичилтийг хадгалж байдаг сүлжээ гэсэн гурван гол хэсгээс бүрдэнэ.

Блокчейн бол мэдээлэл агуулсан багцуудын тодорхой дүрмийн дагуу тасралтгүй цуварсан гинжин сүлжээ юм. Нэг багц нь тодорхой хэмжээний мэдээллийг агуулах бөгөөд багтаамжийн хязгаартай. Багц мэдээллээр дүүрвэл хаагдаж, түрүүчийн дүүрсэн багцад холбогдоно. Энэ мэтчилэн багцууд гинж үүсгэх бөгөөд үүнийг блокчейн буюу багцуудын гинжин сүлжээ гэнэ. Багцууд хоорондоо дугаарлалтаар төдийгүй бас өөрт агуулсан болон өөрийн өмнөх багцын нууц кодоор (*hash sum or hash code*) холбогдоно.

Эд юмсын интернет (*Internet of Things*) нь программ хангамж, ухаалаг мэдрэгч, электрон асаагуур, унтраагч зэргийг суулгасан бүхий л эд зүйлсийг хооронд нь холбож, мэдээлэл дамжуулах, хүлээн авах, алсаас удирдах, хянах, тохируулах нэгдсэн систем юм. Энэ нь зөвхөн 5G хэмээх асар хурдтай интернетийн тусламжтайгаар бүтсэн билээ. Эд юмсын интернетийг эдүгээ олон салбарт үр дүнтэй хэрэглэж байна. Үүний хамгийн энгийн хэрэглээний жишээ нь ухаалаг гэр юм. Гэрийн дулаан, гэрэлтүүлэг, агаарын солилцоо, аюулгүй байдлын дохиолол, видеоогоор ажиглах, хянах зэрэг ажиллагааг алсаас удирдаж, тохируулж байна.

Үүлэн тооцоолох систем нь интернетээр дамжуулан хэрэглэгчдэд янз бүрийн үйлчилгээ үзүүлэх систем бөгөөд үүнд мэдээлэл хадгалах, бусадтай харилцах, мэдээлэл солилцох, мэдээлэл хайх, программ авах зэрэг олон төрлийн үйлчилгээ багтана. Уг системийн тусламжтайгаар хэрэглэгчид өөрсдийн мэдээллээ алс хол байгаа серверт хадгалах, түүнийгээ хэзээ ч ашиглахаас гадна тэндээс янз бүрийн мэдээлэл авах боломжтой болно.

Хиймэл оюун нь хүний гүйцэтгэж байсан зарим бүтээлч үйлдлийг ухаалаг системээр орлуулах чадвар юм. Аж үйлдвэрийн IV хувьсгалын өрнөлийн явцад явцуу хиймэл оюунаас ерөнхий хиймэл оюунд шилжинэ гэж үзэж байна. Зарим эрдэмтэд 2040-2050 оны үед энэ шилжилт явагдах магадлалыг 50%-тай, харин 2075 он гэхэд уг магадлал 90% болно гэж үзэж байна.[10]

Үйлдвэрлэл, үйлчилгээний процессийн роботжуулалт ба автоматжуулалт улам бүр нэмэгдэж байна. Тэр ч байтугай үйлдвэрлэл, үйлчилгээг удирдах, хянах, тохируулах ажиллагааг хиймэл оюуны тусламжтайгаар хийж эхэлсэн. Дэлхийн эдийн засгийн чуулга уулзалтын мэдээгээр 2018 онд үйлдвэрлэлийн нийт ажлын цагийн 29%-нь роботжсон байсан бол энэ үзүүлэлт 2025 он гэхэд 50%-д хүрнэ гэж үзэж байна. 2018 онд роботын тоо 422 мянгаар нэмэгдсэн бөгөөд эдгээрийн дөрөвний гурав нь Хятад, Япон, Өмнөд Солонгос, АНУ, Германд ногдож байна. Сингапурт 10000 ажилтанд 831 робот ногдож байгаа бол энэ үзүүлэлт Өмнөд Солонгост 774, Европт 114 байв.[11]

Робот хэрэглэх замаар үйлдвэрлэлийг иж бүрэн автоматжуулах нь олон давуу талыг бий болгоно. Тухайлбал, робот үйлдвэрлэлийн ажиллагааг хүнээс хурдан чанартай хийхийн зэрэгцээ бага зардал шаардана. Жишээ нь, нэг ажилчны нэг цагийн хөдөлмөр Германд 40 евро, Хятадад 10 евро бол роботын нэг цагийн ажлын өртөг 5-8 евро юм. Хөдөлмөрийн зардлыг бууруулснаар үйлдвэрлэлийн зардлыг багасгаж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлнэ. Мөн бүтээгдэхүүн, үйлчилгээний чанар сайжирч, гологдол гарах нөхцөл хаагдана.

Бүтээгдэхүүний зураг, загварыг хийхээс эхлээд үйлдвэрлэж, эцсийн бүтээгдэхүүн болгох хүртэлх бүхий л ажиллагааг тоон технологийн тусламжтайгаар гүйцэтгэж байна. 3D хэвлэлт, ухаалаг үйлдвэр зэрэг нь шинэ технологийн бодит жишээ юм. 3D хэвлэлт нь тоон программын удирдлага бүхий төхөөрөмж бөгөөд аливаа эд зүйлсийг үечлэн давхарлах аргаар хийнэ. Харин био хувьлагч технологи нь амьд эд эс агуулсан дуслуудаар амьтан, хүний эрхтэн хийхэд хэрэглэгдэнэ. 2018 онд хүний эсээр жижигрүүлсэн зүрх хийж амьтан дээр туршсан нь амжилттай болов. Хятадад биопринтер дээр амьд эс эдээр хүний чих, элэг, бөөр хийсэн байна.

Эдүгээ 5G хэмээх хөдөлгөөнт холбооны тав дахь үеийн дамжуулагчгүй хурдны технологи эрчтэй хөгжиж байна. Энэ нь виртуаль /үүсгэмэл/ бодит байдлыг ашиглах бололцоог олгож байна. Сүүлийн үед Metaverse хэмээх хиймэл орчин онцгой анхаарал татаж байна. Энэ нь интернетийн сүлжээн дэх янз бүрийн виртуаль орон зай бүхий 3D орчин бөгөөд тэнд хүмүүс уулзаж, тоглож, ажиллаж болно. Виртуаль бодит байдлын технологийг блокчейнтэй хослуулснаар мета орчинд зөвхөн ярилцаж, тоглох биш, бас нууц мөнгөний арилжаа хийх, ажил хэргийн гэрээ байгуулах, янз бүрийн арга хэмжээ зохион байгуулах боломжтой болж байна. Үүний тулд хүмүүс сүлжээнд нэвтэрч дижитал түрийвч, дижитал гарын үсэгтэй болох хэрэгтэй.

Тухайн хэрэгсэл тухайн цаг мөчид чухам хаана байгааг тодорхойлж мэдээлэх технологийг байрлал илрүүлэх технологи гэнэ. Тухайн хэрэгслийн байрлалыг илрүүлснээр түүний хэрэглэгчийн байршлыг тодорхойлно гэсэн үг. Гар утас, зөөврийн компьютер, хувийн дижитал туслагч, тоглоомын удирдлага зэрэг хэрэгслийн байршлыг тодорхойлох боломжтой. Жишээ нь, дэлхий дэх байрлалын систем (Global positioning system-GPS) нь АНУ-ын Батлан хамгаалах яамны бүтээж, ажиллуулж буй 24 хиймэл дагуулаас бүрдэх сүлжээ юм. Байрлал илрүүлэх дамжуулагчгүй технологийг ашиглан янз бүрийн үйлчилгээ үзүүлэх болсон. Тухайлбал, хэрэглэгч аль нэг газар луу явахад нь замчлахын зэрэгцээ мөн тэр газар дахь цаг агаарын байдал, замын түгжрэл, зам дагуу ойр байрлах үйлчилгээний газар, дэлгүүр зэргийг зааж өгнө.

**Ногоон эдийн засаг.** Ногоон эдийн засаг бол шинэ эдийн засгийн зорилго бөгөөд төвлөрсөн илэрхийлэл юм. Учир нь хүн төрөлхтөний ирээдүй ногоон эдийн засагтай шууд бөгөөд нягт холбоотой. Хүлэмжийн хийн ялгарал ихсэж, дэлхийн дулаарал нэмэгдэж, байгаль орчны доройтол өргөжиж, байгалийн нөөц хомсдохын хамт хуучин эдийн засгаас ногоон эдийн засагт шилжих асуудал хүчтэй тавигдаж эхэлсэн билээ. Иймд эдийн засаг, нийгэм, байгаль орчны харилцан хамаарал, уялдаа холбоог тэнцвэртэй хадгалж хөгжих тогтвортой хөгжлийн үзэл санааг анх 1992 онд Бразилийн Рио де Жанейро хотод болсон Тогтвортой хөгжлийн асуудлаарх дэлхийн дээд хэмжээний уулзалтаас



дэвшүүлж, улмаар дараа дараагийн уулзалтуудаас дэлхий нийтийн эрхэм зорилго болгон зарласан юм.

Хамгийн сүүлд 2021 оны 10 дугаар сард Их Британий Глазгоу хотноо НҮБ-ын Уур амьсгалын өөрчлөлтийн бага хурлын 26 дахь уулзалт болж, түүнээс гаргасан “Глазгоугийн уур амьсгалын гэрээ” хэмээх баримт бичигт дэлхийн дулаарлыг 2 хэмээс үлэмж доош хэмжээнд барих, 1.5 хэмээс хэтрүүлэхгүй байх зорилтыг тунхаглав. 2030 он хүртэл нүүрсхүчлийн хийн ялгаруулалтыг 45 хувиар багасгаж, 2050 он гэхэд тэг түвшинд хүргэхээр тохиров[12].

Ийнхүү ногоон эдийн засаг өнөө үеийн эдийн засгийн хөгжлийн гол чиглэл болж байна. Ногоон эдийн засгийн тухайд нэгдсэн гэхээр тодорхойлолт алга. Америкийн эдийн засагч Карл Буркарт ногоон эдийн засаг нь 1) сэргээгдэх эрчим хүч, 2) ногоон барилга, байгууламж, 3) тогтвортой тээвэр, 4) усны менежмент, 5) хог хаягдлын менежмент, 6) газрын менежмент гэсэн гол салбаруудад тулгуурлана гэжээ[13].

Олон улсын худалдааны танхимын илтгэлд “Ногоон эдийн засаг бол эдийн засгийн өсөлт ба байгаль орчныг хамгаалах хариуцлага хоёр харилцан бие биенээ дайчилж, хамтран үйлчлэх хэлбэр бөгөөд нийгмийн хөгжлийг дэмжихэд чиглэгдэнэ”[14] гэжээ. Тус илтгэлд ногоон эдийн засагт шилжихэд бизнесийн үүрэг их болохыг дурдаад дараах 10 нөхцөлийг хамтран бүрдүүлэх шаардлагатайг тэмдэглэжээ. Үүнд, 1) нээлттэй ба өрсөлдөөнт зах зээл, 2) тайлан, тооцоо, хэмжүүр, 3) санхүүжилт ба хөрөнгө оруулалт, 4) олон нийтийн ойлголт, дэмжлэг, 5) эхнээс нь эцсийг нь хүртэлх мөчлөг гэж ойлгох, 6) нөөцийг үр ашигтай ашиглах, 7) ажил эрхлэлт, 8) боловсрол ба ур чадвар, 9) удирдлага ба түншлэл, 10/ нэгдсэн бодлого, шийдвэр гаргалт.[15]

Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага “ногоон өсөлт”-ийн үзэл баримтлалыг боловсруулсан бөгөөд энэ нь байгалийн нөөцийн тоо, чанарт хор хохирол учруулахгүйгээр байгаа чадавх, боломжийг ашиглан эдийн засгийн өсөлтийг хангах явдал гэж тодорхойлжээ.[16]

Ногоон эдийн засгийн тухай дээрх тодорхойлолтууд түүний бүтэц, агуулгыг бүрэн гаргаж чадахгүй байна. Бидний бодлоор ногоон эдийн засаг дараах үндсэн хэсгүүдээс бүрэлдэнэ гэж үзэж байна. Үүнд: 1) сэргээгдэх эрчим хүч, 2) үйлдвэрлэлийн хаягдал багатай технологи ба хуучирч, эвдэрсэн эдлэлийг шинэ болгох үйлдвэрлэл, 3/ эрчим хүч, шатахууны хэрэглээ болон материалын орцыг эрс багасгах, тэдгээрийн шинэ эх үүсвэрийг бий болгох технологи, 4) хэрэглээний шинэ соёлыг төлөвшүүлэх, эд юмсын хэрэглээг уртасгах, 5) хог хаягдал, ашигласан усыг дахин боловсруулах, цэвэршүүлэх технологи, 6) байгаль орчин, агаарын бохирдлыг зогсоох эдийн засаг, захиргааны арга хэмжээ, 7) дээрх бүх шинэчлэлийг дэмжиж урамшуулсан санхүү, зээлийн систем, 8) төр, хувийн хэвшлийн үр ашигтай түншлэл 9) нийт хүн амын дэмжлэг, оролцоо зэрэг болно.

Өөрөөр хэлбэл, ногоон эдийн засаг нь үйлдвэрлэлийн процесс, бүтээгдэхүүний хуваарилалт, хэрэглээ, дахин боловсруулалт, дахин ашиглалт гэсэн капиталын эргэлтийн бүхэл орчил, амьдрал, ахуйн бүхий л хүрээг хамарч, тэр бүрт ногоон эдийн засгийн зарчим, шаардлагуудыг хэрэгжүүлэх үйл явц юм. Ногоон эдийн засаг нь дижитал эдийн засаг, эргэлтийн эдийн засаг, хамтын

хэрэглээний эдийн засаг зэрэгтэй бүх талаар нягт уялдаа, холбоотой юм. Ногоон эдийн засгийн бүрэлдэхүүн хэсгүүдийг Зураг 3-аас үзнэ үү.

Ногоон эдийн засгийг зөвхөн сэргээгдэх эрчим хүчээр төсөөлөх нь учир дутагдалтай. Сэргээгдэх эрчим хүч нэмэгдлээ ч гэсэн үйлдвэрлэлийн шинэ технологийг бий болгож, орцыг багасгаж, гарцыг ихэсгэж чадахгүй бол үрлэгэн эдийн засаг хэвээр үлдэж, байгаль орчинд сөргөөр нөлөөлсөөр байх болно. Ялангуяа үйлдвэрлэлийн процесст ашигласан усыг цэвэршүүлэн ашиглах технологийг нэвтрүүлэхгүй орхивоос ногоон эдийн засгийг хөгжүүлж чадахгүй. Хог хаягдал төдийгүй хуучирсан, эвдэрсэн эд зүйлсийг дахин боловсруулах технологийг бүтээхгүй бол хэмнэлттэй эдийн засгийг бүрдүүлэх боломжгүй.

Хуучин эдийн засгаас ногоон эдийн засагт шилжихэд их хэмжээний хөрөнгө оруулалт, зардал шаардана. Иймд уг шилжилтийг дэмжих, урамшуулах зээл, санхүүгийн таатай нөхцөл бүрдүүлэх зайлшгүй шаардлагатай. Түүнчлэн энэхүү том зорилтыг төр засаг зохион байгуулж, хувийн хэвшилтэй бүтээлчээр түншилж ажилласнаар шийдвэрлэнэ. Гэхдээ энэ том шилжилт нь зөвхөн төр, хувийн хэвшлийн үүрэг биш, түүнд нийт хүн ам ухамсарлан оролцож байж хэрэгжинэ.

*Зураг 3. Ногоон эдийн засгийн бүрэлдэхүүн хэсгүүд*

Сэргээгдэх эрчим хүч	Үйлвэрлэлийн хаягдал багатай технологи	Эрчим хүч, шатахуун, материалын хэмнэлттэй хэрэглээ
Хэрэглээний шинэ соёл	Хог хаягдал, ашигласан усыг дахин хэрэглэх технологи	Байгаль орчны бохирдлыг зогсоох арга хэмжээ
Ногоон эдийн засгийг дэмжсэн санхүү, зээлийн систем	Төр, хувийн хэвшлийн үр ашигтай түншлэл	Хүн амын дэмжлэг, оролцоо

**Эргэлтийн эдийн засаг.** Шинэ эдийн засаг нь юуны өмнө байгаль орчны бохирдлыг багасгах, дэлхийн дулаарлыг хязгаарлах, үүний тулд материал, түүхий эд болон эд юмсыг хамгийн ариг гамтай хэрэглэх, дахин хэрэглэх, хог хаягдлыг багасгах, үүний тулд орчин үеийн шинэ технологи хэрэглэхэд чиглэгдэнэ. Шинэ эдийн засгийн бүрэлдэхүүний нэг хэсэг дижитал эдийн засаг

хөгжихийн хамт эргэлтийн эдийн засаг өргөжих боломжтой боллоо. Эргэлтийн эдийн засгийг мөн чанараар нь хаягдалгүй эдийн засаг гэж нэрлэж болно.

Эргэлтийн эдийн засаг гэдэг бол материал, бүтээгдэхүүнийг ашиглах, дахин ашиглах, засварлах, шинэчлэн засварлах, хамтран хэрэглэх, түрээслэх зэргээр хамгийн үр ашигтай, хаягдал багатайгаар үйлдвэрлэл, хэрэглээг зохион байгуулах загвар юм. Эргэлтийн эдийн засаг нэгд, хаягдал болон бохирдлыг арилгах, хоёрт, бүтээгдэхүүн болон материалыг эргэн ашиглах, гуравт, байгалийн дахин сэргээх гэсэн зарчмуудад үндэслэгдэнэ.

Шугаман буюу хуучин эдийн засагт байгалийн нөөц бүтээгдэхүүн болж хувираад эцэст нь хог хаягдал болж дуусдаг. Энэ нь үйлдвэрлэлийн хуучин технологи, загвар зохион бүтээх хоцрогдсон арга ашиглаж байсантай холбоотой. Харин эргэлтийн эдийн засаг бол байгалийн нөөц ашиглалтыг багасгах, хаягдал гарахыг зогсоох, ашигласан материал, бүтээгдэхүүнийг дахин боловсруулах, дахин ашиглах, шинэчлэн засварлахад бүүр анхнаасаа чиглэгдсэн байна. Хаягдал материал, эрчим хүчийг өөр юм үйлдвэрлэхэд ашигласнаар тэдгээрийн үнэ цэнийг дахин өсгөнө. Эргэлтийн эдийн засгийн бүтцийг Зураг 4-т үзүүлэв.

Зураг 4. Эргэлтийн эдийн засаг



Дижитал эдийн засаг бол эргэлтийн эдийн засгийг хөгжүүлэх чухал үндэс болж байна. Их өгөгдөл, эд юмсын интернет, хиймэл оюун, блокчейн зэрэг дижитал технологийг тогтвортой нөөцийн менежменттэй хослуулах замаар эргэлтийн эдийн засгийг хөгжүүлнэ. Өөрөөр хэлбэл, материал болон бүтээгдэхүүний эргэлтийг нэмэгдүүлэх, тэдгээрийн ашиглалтын хугацааг

уртасгах, шинэчлэн сэргээх боломжийг судлах, хэрэгжүүлэхэд тоон технологийг ашиглана.

2020 оны байдлаар дэлхийн эдийн засгийн ердөө 8.6% нь эргэлтийн эдийн засаг байгааг РАСЕ-ийн илтгэлд дурджээ. Эргэлтийн эдийн засгийг өргөтгөх зорилтыг эдийн засгийн олон салбар хэрэгжүүлж эхэллээ. Тухайлбал, нэхмэлийн салбарт өмсөж, эдэлж байсан хувцас, материалыг дахин боловсруулж, үйлдвэрлэлд дахин оруулж, шинэ загвар, хэлбэр бүхий бүтээгдэхүүн үйлдвэрлэх ажил явагдаж байна.

Нисэх онгоцны үйлдвэрлэлийн салбарт ашиглах хугацаа нь дуусаж хуучирсан онгоцыг бүрэн задалж, дотроос нь хар хайрцаг, удирдлагын самбар зэрэг дахин ашиглаж болох аппарат хэрэгсэл, эд зүйлс болон хөнгөн цагаан, зэс утас, хэрэгслүүдийг ялган авсны дараа эх биеийг хэмхлэн жижигрүүлж, дахин хайлуулах замаар шинэ онгоц хийхэд ашиглах болжээ. Ингэж хуучин онгоцыг задалж дахин боловсруулахад 20 хувь нь л хаягдал болдог ажээ.

Автомашин үйлдвэрлэл эргэлтийн эдийн засагт шилжиж эхэллээ. Тухайлбал, Францын Renault компани дараах гурван шинэчлэлийг үйлдвэрлэлд нэвтрүүлжээ. Нэгд, хуучин машины зарим эд ангийг, тухайлбал, хурдны хайрцаг, турбо хөдөлгүүрийн шахуурга зэргийг дахин шинэчилж үйлдвэрлэх болсон. Хоёрт, хуучирсан машины хуванцар хэсгийг дахин боловсруулж, шинэ машин хийхэд ашиглаж байна. Гуравт, ашиглалт нь дууссан цахилгаан батерейг дахин засаж цэнэглэн, шинэ юм шиг болгон хэрэглэх болов.

Энэ мэтчилэн эргэлтийн эдийн засгийн загварыг барилга, мебель, модон эдлэлийн үйлдвэрлэл, хөдөө аж ахуй зэрэг олон салбарт амжилттай нэвтрүүлж байна.

**Бусадтай хуваалцах эдийн засаг.** Хүмүүс эд хөрөнгө, мэдлэг чадвараа ашиглахгүй байгаа үедээ бусад ашиглуулан, бусадтай хуваалцаж, орлого олох зорилготой эдийн засгийн харилцааг бусадтай хуваалцах эдийн засаг гэж нэрлэжээ. Энэхүү харилцаанд нэг талаас, эд хөрөнгө, мэдлэг чадвараа ашиглахгүй байгаа үедээ бусадтай хуваалцах сонирхолтой хүмүүс, нөгөө талаас, уг эд хөрөнгө, мэдлэг чадварыг нь түр хэрэглэх шаардлагатай хүмүүс, мөн тэднийг хооронд нь зуучлан холбох гуравдагч этгээд гэсэн субъектүүд оролцоно. Бусадтай хуваалцах эдийн засгийн үйлчлэх гол механизм нь мэдээлэл, харилцааны технологи юм.

Бусадтай хуваалцах эдийн засгийн дараах жишээг дурдаж болно. Үүнд: АНУ-ын Uber, Zipcar зэрэг компани хэрэглэгчдийн автомашиныг ашиглахгүй байгаа үед нь зуучилж бусад түрээслэх үйлчилгээ үзүүлдэг. Судалгаанаас үзэхэд хувийн автомашин ашиглагдах нийт хугацааныхаа 95 хувийг сул зогсож өнгөрөөдөг ажээ.[17] АНУ-ын Airbnb компани хэрэглэгчдийн орон сууцны ашиглахгүй байгаа өрөө юмуу байрыг бусад түрээслүүлэх үйлчилгээ эрхэлдэг.

Түүнчлэн хоол хийж хүргэж, хувцас түрээслэх, янз бүрийн засвар, үйлчилгээг зуучлах, хүүхэд, өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг асарч харуулах, гэрээр хичээл заах, хичээлийн хоцрогдлыг нөхөх, их сургуулийн шалгалтад бэлтгэх, гадаад хэл сурах, гэрээр хөгжим заалгах, эдэлж хэрэглэж байсан зүйлсээ худалдах, солилцох зэрэг янз бүрийн үйлчилгээ өргөжиж байна. Хамтын санхүүжилт (Crowdfunding) нь интернетийн сүлжээ, дижитал платформ ашиглан хэн нэгэнд шаардлагатай санхүүжилтийг босгох

арга юм. Жишээ нь, улс төрчид уг аргыг ашиглан сонгуулийн кампанит ажилд шаардагдах хөрөнгийг босгодог болжээ. Монголд хэн нэг нь хүндээр өвчилж, гадаадад эмчлүүлэх шаардлагатай болсон үед олон нийтээрээ мөнгө цуглуулж тусалдаг сайн жишээ бий.


Бусадтай хуваалцах эдийн засаг нь хуучин эдийн засагтай харьцуулахад дараах давуу талтай. Нэгд, хүмүүсийн хэрэгцээт бараа, үйлчилгээний нэр төрөл улам олон болно. Учир нь, одоо үйлдвэрлэхээ байсан зарим зүйлийг ч бусдаас олж болно. Хоёрт, хүмүүс хоорондоо интернетээр шууд харилцаж, түрээслэх, солилцох болон худалдах бараа, үйлчилгээгээ бие биэндээ харуулж, сонголт хийх боломжийг хангана. Гуравт, байр, машин зэрэг эд хөрөнгөө ашиглахгүй үедээ бусдад түрээслүүлж, хувийн орлогоо нэмэгдүүлнэ. Дөрөвт, түрээсийн болон худалдах үнэ хямд байна. Жишээ нь, айлын байр юмуу өрөө түрээслэх нь зочид буудалд хонохоос хямд байна. Автомашин түрээслэх нь такси авснаас хямд тусна.

Тавд, өндөр үнэтэй, жилд цөөн хэрэглэдэг зүйлсийг түрээсээр авч хэрэглэснээр ихээхэн хэмжээний зардал хэмнэнэ. Энэ нь ялангуяа мөнгө хөрөнгө багатай хүмүүст их хэрэгтэй юм. Зургаад, эдийн засгийн энэ хэлбэр нь байгаль орчныг хамгаалах, бохирдлыг багасгахад чухал ач холбогдолтой. Шинээр юм үйлдвэрлэхийн оронд байгаа юмыг сайтар ашиглах нь байгалийн нөөцийг хэмнээд зогсохгүй үйлдвэрлэлээс гарах хаягдал, бохирдлыг багасгаж, эрчим хүч хэмнэнэ. Долоод, хүмүүс үндсэн ажлынхаа хажуугаар давхар ажил хийх боломж нэмэгдэж, орлогоо өсгөх нөхцөл бүрэлдэнэ. Наймд, нийгэмд хүмүүс хоорондын итгэлцлийг бэхжүүлнэ.

Шинэ эдийн засгийн бүрэлдэхүүний эдгээр таван хэсэг хоорондоо нягт уялдаатай, харилцан хамааралтай юм. Шинэ эдийн засгийн гол эх сурвалж нь мэдлэгийн эдийн засаг бол үндсэн хөдөлгөгч хүч нь дижитал эдийн засаг юм. Харин ногоон эдийн засаг бол шинэ эдийн засгийн төвлөрсөн илэрхийлэл мөн. Эцсийн эцэст хүн төрөлхтөний ирээдүй гагцхүү ногоон эдийн засагтай холбоотой. Ногоон эдийн засгийг бүрдүүлэхийн тулд эргэлтийн эдийн засаг, бусадтай хуваалцах эдийн засгийг хөгжүүлэх ёстой. Эдгээр нь гагцхүү дижитал эдийн засгийн хөгжилд тулгуурлана. Энэ бүхнээс үзэхэд шинэ эдийн засгийг бүрдүүлэхийн тулд түүний бүрэлдэхүүн хэсгүүдийг цогцоор нь нарийн уялдаатай хөгжүүлэх хэрэгтэй.

Эдүгээ дэлхий дахинд хуучин эдийн засаг давамгайлсан хэвээр, харин шинэ эдийн засаг улам бүр тэлж байна. Хуучин эдийн засаг гэдэг бол аж үйлдвэрийн IV хувьсгалын өмнөх үеийн эдийн засаг мөн. Өнөөгийн эдийн засаг бол хуучин ба шинэ эдийн засгийн аль алиныг агуулсан холимог эдийн засаг юм. Ийм холимог байдал нэлээд хугацаагаар үргэлжлэх бөгөөд ингэхдээ хуучин эдийн засгийн эзлэх хувь хэмжээ багасаж, харин шинэ эдийн засгийн хувь хэмжээ улам бүр өссөөр байх болно. Одоо хуучин эдийн засаг давамгайлж байгаа бол энэ XXI зууны дунд үе хүртэл хуучин ба шинэ эдийн засгийн харьцаа ойролцоо болж ирнэ гэж тооцож байна. Харин XXI зууны II хагас бол шинэ эдийн засаг хуучнаа бүрэн халах үе байх болно. Хуучин ба шинэ эдийн засгийн ялгааг Зураг 5-аас харна уу.

Зураг 5. Хуучин ба шинэ, эргэлтийн эдийн засгийн ялгаа



Монгол Улсад шинэ эдийн засгийг хөгжүүлэхийн тулд дижитал технологийг өргөн нэвтрүүлэх, энэ үндсэн дээр юуны өмнө хог хаягдлыг дахин боловсруулах, ашигласан усыг цэвэршүүлж дахин ашиглах гэсэн хоёр зорилтыг шийдвэрлэж эхлэх хэрэгтэй. Хог хаягдлыг газарт булаах биш, харин аль болохоор дахин боловсруулж ашиглах нь материал, түүхий эд, туслах материалын ихэнхийг нь гадаадаас авдаг манай орны хувьд нэн чухал ач холбогдолтой юм. АНУ-ын Мянганы сорилтын сангийн хоёр дахь компакт гэрээний санхүүжилтээр Улаанбаатар хотод Ус дахин боловсруулах үйлдвэр байгуулах ажил эхэлсэн нь шинэ эдийн засагт шилжих анхны томоохон алхам юм. Тус үйлдвэр төв цэвэрлэх байгууламжаас байгальд гаргаж буй усыг дахин боловсруулж, дулааны III ба IV цахилгаан станцыг техникийн усаар хангах бөгөөд ингэснээр жилд 18 сая куб метр гүний усыг орлуулах юм[18].

Хуучин эдийн засгийг халах үйл явц нүүрсний хэрэглээг хязгаарлахаар эхэлсэн тул Монгол Улс 2030 оноос наана нүүрсний болон эрчим хүчний салбарт дараах бодлогыг боловсруулж хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзэж байна. Үүнд, нэгд, нүүрсний экспортын төмөр замыг яаралтай дуусгаж, экспортыг нэмэгдүүлэх нь нэн чухал. Үүний тулд БНХАУ-д нүүрс гаргах шинэ боомтыг нээж, төмөр замаар холбоход хөрөнгө хүчийг төвлөрүүлбэл зохино. Уг экспортоос олсон хөрөнгийн зарим хэсгийг баялгийн санд шилжүүлэн хуримтлуулж, эрчим хүчний шинэ эх үүсвэр ашиглахад зориулах нь зүйтэй.

Хоёрт, Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станцыг байгуулахын зэрэгцээ Эгийн голын усан цахилгаан станц байгуулах төслийг ОХУ-тай хэлэлцэн тохиролцоо нь нэн чухал. Гуравт, ОХУ-аас БНХАУ руу Монголын нутгаар дамжуулан тавих байгалийн хийн хоолойн төсөлд идэвхтэй оролцож, байгалийн хийгээр ажиллах цахилгаан станц байгуулах ажлыг судалж, шийдвэрлэвэл зохино. Дөрөвт, Глазгоугийн уур амьсгалын гэрээнд хөгжилтэй орнуудаас хөгжиж буй орнуудад эрчим хүчний шилжилт хийхэд нь туслах тухай заасныг ашиглан Монголд усан цахилгаан станц байгуулах, мөн нарны болон салхин цахилгаан станц барих хөрөнгийн эх үүсвэрийг олох талаар бүх шугамаар идэвхтэй ажиллуштай. Хөгжилтэй орнуудаас хөгжиж буй орнуудад эрчим хүчний шилжилт хийхэд нь туслах зорилгоор жил бүр 100 тэрбум ам.долларын хөрөнгө гаргах тухай уг баримт бичигт заасан[19].

### **Ш. Шинэ эдийн засаг ба шинэ улс төрийн эдийн засгийн ухаан**

Шинэ эдийн засгийг эдийн засгийн ямар ухаан судлах вэ гэсэн асуулт гарах нь дамжиггүй. Бидний өмнө үзэж, уншиж ирсэн сонгодог улс төрийн эдийн засгийн ухаан, экономикс, макро ба микро эдийн засгийн ухаан зэрэг нь шинэ эдийн засгийг судалж шинжлэх боломжтой юу гэсэн асуулт бас гарна. Энэ бүгдэд нэг мөр хариу өгөх төвөгтэй ч гэсэн шинэ зүйлийг хуучин аргаар судлах нь учир дутагдалтай гэсэн логик хариуг юуны өмнө өгч болно.

Шинэ эдийн засаг хөгжихийн хамт бидний өмнө олон шинэ асуудал тулгарах төлөвтэй. Тухайлбал,

- шинэ эдийн засаг ажилгүйдлийг нэмэгдүүлэх үү
- шинэ эдийн засгийг хөгжүүлэх шинэ хүчнийг хэрхэн бэлтгэх вэ
- шинэ эдийн засаг эдүгээ нэн өргөн хүрээтэй байгаа ядуурлыг бууруулах уу
- шинэ эдийн засаг хүн амын орлогын ялгааг багасгах уу
- шинэ эдийн засаг иргэдийн олонхын амьдралын түвшин, чанарыг дээшлүүлэх үү
- шинэ эдийн засаг эдийн засаг, санхүүгийн хямралаас урьдчилан сэргийлж чадах уу
- шинэ эдийн засаг боловсрол, эрүүл мэнд зэрэг нийгмийн салбарын хөгжилд хэрхэн нөлөөлөх вэ
- шинэ эдийн засаг улс төрөөс хэр хамааралтай хөгжих вэ
- шинэ эдийн засаг авилга, хээл хахууль зэрэг нийгмийн сөрөг үзэгдлийг арилгаж чадах уу
- шинэ эдийн засаг баян, ядуу орнуудын хөгжлийн ялгааг багасгах уу, ихэсгэх үү
- шинэ эдийн засаг улс хоорондын худалдааны дайныг намжаах уу, эсхүл улам хурцатгах уу
- шинэ эдийн засаг улс хоорондын зэвсэгт мөргөлдөөн, дайн дажныг зогсооход нөлөөлөх үү
- шинэ эдийн засаг дэлхий дахины хуваагдлыг арилгахад нөлөөлөх үү, эсхүл түүнийг улам гүнзгийрүүлэх үү гэх мэт.

Энэ мэт олон асуулт гарах бөгөөд тэдгээрийн хариултыг олоход эдийн засгийн аль нэг ухааныг хэрэглэх нь явцгүй. Бидний бодлоор шинэ эдийн засгийг шинэ улс төрийн эдийн засгийн ухаан судлана. Учир нь энэ нь эдийн засаг, улс төрийн шинжлэх ухааны олон салбарыг хамран шинэ тутам хөгжиж буй шинжлэх ухаан юм. Шинэ улс төрийн эдийн засгийн ухааны талаар олон янзаар тодорхойлж буй талаар бид өмнө нь авч үзсэн[20].

Харин бид “Шинэ улс төрийн эдийн засгийн ухаан нь сонгодог улс төрийн эдийн засгийн ухаан, макро эдийн засгийн онол болон улс төр судлалын зарим онол, урсгалын нийлбэр цогц юм гэж үзэж байна.”[21] Өөрөөр хэлбэл, шинэ улс төрийн эдийн засгийн ухаан нь сонгодог улс төрийн эдийн засгийн ухааныг орчин үеийн эдийн засгийн болон улс төр судлалын онол, урсгалуудаар баяжуулсан шинжлэх ухаан юм.

Шинэ улс төрийн эдийн засгийн ухааны судлах зүйл дараах хэсгүүдээс бүрдэнэ гэж үзэж байна. Үүнд, нэгд, сонгодог улс төрийн эдийн засгийн ухаан

Үйлдвэрлэлийн буюу эдийн засгийн харилцааг үйлдвэрлэх хүчний хөгжлийн түвшин, шинж чанартай холбон судалдаг бол шинэ улс төрийн эдийн засгийн ухаан эдийн засгийн харилцааны өөрчлөлтийг технологийн дэвшлийн нөлөөтэй холбон судална. Тухайлбал, робот технологи үйлдвэрлэлд өргөнөөр нэвтэрч, үйлдвэрлэлийн процесс иж бүрэн автоматжигдах нь ажиллах хүчний эрэлт, нийлүүлэлт, бүтээмжийн өсөлт ба цалин хөлсний хэмжээ, ажилгүйдэлд хэрхэн нөлөөлөх асуудлыг судална.

Хоёрт, шинэ улс төрийн эдийн засгийн ухаан нь эдийн засгийн хөгжлийг байгаль орчныг хамгаалах асуудалтай нягт холбоотой судална. Дэлхийн цаг уурын өөрчлөлтийн нөхцөл дэх эдийн засгийн шинэ харилцаа, шинэ зорилт, шинэ технологийн дэвшил болон цаашид хүн төрөлхтөн оршин амьдрах гол нөхцөл болсон байгаль орчныг хамгаалах явдал эдүгээ онцгой чухал асуудал болж байна.

Гуравт, шинэ улс төрийн эдийн засгийн ухаан нь эдийн засгийн хөгжлийг түүний аюулгүй байдлын асуудалтай нягт уялдаатай авч үзнэ. Улс үндэстэний оршин тогтнох үндэс нь эдийн засгийн аюулгүй байдал буюу эдийн засаг нь харьцангуй бие дааж хөгжих чадвартай байх явдал юм. Шинэ эдийн засгийн нөхцөлд эдийн засгийн аюулгүй байдлын асуудал улам хурцаар тавигдах боллоо. Ялангуяа кибер аюулгүй байдал гэсэн том асуудал босож ирсэн. Иймд эдийн засгийн хөгжлийн асуудлыг судлахдаа түүний аюулгүй байдлыг хангах арга замыг ямагт хамт тодорхойлох шаардлагатай болж байна.

Дөрөвт, шинэ эдийн засаг нь үндсэндээ мэдлэгийн эдийн засаг учир түүний өсөлтийг боловсрол, шинжлэх ухааны хөгжилтэй холбон судална. Сонгодог улс төрийн эдийн засгийн ухаан ажиллах хүчний эрэлт, нийлүүлэлтийн асуудлыг голлон авч үздэг бол шинэ улс төрийн эдийн засгийн ухаан нь хүмүүн капитал, оюуны капиталын өсөлтийг судална.

Тавд, шинэ улс төрийн эдийн засгийн ухаан нь эдийн засаг ба улс төр хоорондын харилцан хамаарал, тодруулж хэлбэл, эдийн засгийн тогтолцоо ба улс төрийн институт, төр засгийн харилцаа, харилцан нөлөөллийг судална. Тухайлбал, дижитал эдийн засаг ба дижитал төрийн удирдлагыг хослуулах асуудал, шинэ эдийн засаг ба төрийн зохицуулалтын хэлбэр, хамаарал зэргийг шинжилнэ. Жишээ нь, блокчейн дэх биткойны гүйлгээг төв банкнаас хянах боломжтой эсэх, цаашид шинээр үүсэх мөнгө, санхүүгийн хэрэгслүүдийг хэрхэн зохицуулах зэрэг асуудлыг авч үзнэ.

Зургаад, сонгодог улс төрийн эдийн засгийн ухаан капиталист нийгэм дэх ажилчин ба хөрөнгөтөн анги, тариачин ба жижиг хөрөнгөтөн, худалдаачдын хоорондын харилцааг судалдаг бол шинэ улс төрийн эдийн засгийн ухаан нь нөөц баялгийг хуваарилах талаарх орчин үеийн нийгмийн янз бүрийн бүлэг, давхаргын хоорондын харилцааг судлана. Үүнд, орлогын хуваарилалт, хүн амын доторх орлогын ялгаа, дундаж давхаргыг өргөтгөх асуудал, хүн амын нийгмийн хамгаалал зэрэг асуудлыг шинжилнэ.

Долоод, шинэ улс төрийн эдийн засгийн ухаан нь нийгэм дэх олон янзын ашиг сонирхол, тэдгээрийн зөрчил ба зохицлын асуудлыг судална. Энд зөвхөн нийгмийн, хамт олны болон хувь хүний ашиг сонирхлыг төдийгүй нийгэм дэх янз бүрийн бүлгүүдийн ашиг сонирхлын ялгаа, түүнийг зохицуулах арга замыг тодорхойлно.



Наймд, сонгодог улс төрийн эдийн засгийн ухаан эдийн засгийн өсөлт, эдийн засаг, санхүүгийн хямрал, тэдгээрийн шалтгаан, үр дагаврыг судалдаг бол шинэ улс төрийн эдийн засгийн ухаан нь шинэ эдийн засгийн нөхцөл дэх эдийн засгийн өсөлт ба эдийн засаг, санхүүгийн хямралын онцлог, гарах давтамж, урьдчилан сэргийлэх боломж зэргийг судална.

Есд, шинэ улс төрийн эдийн засгийн ухаан нь Орос, Украины дайнаар эхэлсэн дэлхийн шинэ дэг журмын нөхцөл дэх олон улсын худалдаа, эдийн засгийн харилцааны өөрчлөлт болон онцлогийг судална.

Энэ бүхнээс үзэхэд шинэ улс төрийн эдийн засгийн ухааны судлах зүйл нь сонгодог улс төрийн эдийн засгийн ухааны судлах зүйлээс хамаагүй өргөн хүрээтэй болж байна. Шинэ улс төрийн эдийн засгийн ухаан яагаад зайлшгүй хэрэгтэй вэ гэвэл эдийн засгийн хуучин онол, сургаал өнөөгийн эдийн засгийн зөрчил, хөгжлийн төлөвийг зөв оношлон дүгнэж чадахгүй байгаатай холбоотой. Тухайлбал, 2008 оны санхүү, эдийн засгийн том хямрал хуучин эдийн засгийн онол, урсгалууд учир дутагдалтай болохыг тодорхой харуулав.

Барууны эдийн засгийн онол, ялангуяа АНУ-ын эдийн засагчид тус улсад 2000-аад оны сүүлээр өрнөсөн санхүү, эдийн засгийн хямралыг урьдчилан харж, сэрэмжлүүлэн зайлуулж чадаагүй билээ. Үүнийг АНУ-ын нэр хүндтэй эдийн засагчид хүртэл хүлээн зөвшөөрсөн. Тухайлбал, Нобелийн дурсгалын шагналт, эдийн засагч, Йелийн их сургуулийн профессор П.Кругман 2009 онд бичсэн “Эдийн засгийн ухаан яагаад хүчин мөхөсдөв?” хэмээх томоохон өгүүлэлдээ “Цөөн хэдэн эдийн засагч 2008 оны хямрал ойртож байгааг мэдэрч байсан. Гэхдээ түүнийг урьдчилан харж чадаагүй нь эдийн засгийн ухааны асуудлын багахан хэсэг. Хамгийн гол нь эдийн засгийн шинжлэх ухаан бүхэлдээ зах зээлийн эдийн засгийн ийнхүү сүйрэн гацах боломжийг харах чадваргүй байсан нь гайхалтай.”[22] гэж халаглан бичжээ.

Барууны эдийн засагчдын зарим нь зөвхөн өөрийн онолын хүрээнд эргэлдэж, бусад онол, үзлийг үл тоомсорлон явцуурч, үүнээсээ болоод алдаа гаргадаг нь ажиглагдав. Аливаа юмс, үзэгдэл эсрэг тэсрэгийн нэгдэл, тэмцлийн үр дүнд хөдөлгөөнд орж, одоогийнх нь өмнөхөө үгүйсгэн дороос дээд шатанд дэвшин тооноос чанарт шилжих замаар хөгждөг тухай диалектикийн хуулийг нэг бол судлаагүй, эс бол тоодоггүй нь тэдний алдах шалтгаан гэлтэй. Тухайлбал, монетарист онолынхон зөвхөн мөнгөний нийлүүлэлтийг зохицуулснаар эдийн засгийг удирдаж болно гэж нэг талыг барин туйлширч байна. Гэтэл мөнгөний нөгөө талд бодит эдийн засаг хэмээх бүхэл бүтэн том систем оршин байна. Өөрөөр хэлбэл, мөнгө, санхүүгийн харилцаа бол бодит эдийн засгийн зөвхөн нэг тал бөгөөд түүнийг илэрхийлэх ёстой. Хэрэв уг харилцаа бодит эдийн засгаас даван хөөсрөх аваас түүнээс тасарч, хий хоосон, ямар ч үнэ цэнэгүй баахан цаас, дансан дахь тоо үлдэж, олон хүнийг хохироодог болохыг практик харуулж байна.

Энэ бүхнээс үзэхэд бид эдийн засгийн онолын аль нэг урсгалыг сохроор дагах биш, харин өнөөгийн шинэ эдийн засгийг олон талаас нь судалж, зөв дүгнэлт хийж чадах шинэ улс төрийн эдийн засгийн ухааныг хөгжүүлэх нь чухал юм.

Шинэ эдийн засаг хөгжихийн зэрэгцээ шинэ улс төрийн нөхцөл байдал бий болов. 2022 оны 2 дугаар сарын 24-нд ОХУ-ын зэвсэгт хүчин Украин улсын

нутаг дэвсгэрт халдан довтолсны дараа АНУ тэргүүтэй барууны орнууд ОХУ-ын эсрэг цэрэг, улс төр, худалдаа, эдийн засгийн болон хувь хүмүүстэй холбоотой өргөн хүрээтэй хориг арга хэмжээ авсан бөгөөд үүний улмаас дэлхийн улс төр, эдийн засгийн байдал эрс өөрчлөгдлөө. Дэлхийн II дайнаас хойш 1990 он хүртэл үргэлжилж байсан капиталист ба социалист хоёр системийн хоорондын хүйтэн дайнаас ч илүү дайсагнасан хүчнүүд бий болж, олон улсын харилцааны тогтсон дэг журам эвдэгдэж, цэрэг, зэвсгийн хүчээр асуудлыг шийдэх нөхцөл байдал үүслээ. Улам бүр өргөжин тэлж байсан даяаршил саатаж, хагарал, хуваагдал бий боллоо. Орос, Украины дайн улам бүр сунжирч, Орос ба НАТО-гийн хоорондох дайн буюу дэлхийн III дайн болон өргөжих аюултай нөхцөл байдал үүсэж байна. НАТО-гийн гишүүн орнууд Украинд зэвсэг, техник нийлүүлэх хэмжээгээ нэмэгдүүлсээр уг дайнд улам бүр татагдан орж байна.

Цаашид дэлхийн улс төр, эдийн засгийн харилцаа хэрхэн хөгжих вэ? АНУ, Европын холбоо болон ОХУ-ын хоорондын харилцаа Орос, Украины дайны өмнөх түвшинд эргэн очих боломж бий юү? Дэлхийн III дайн эхлэх үү, хэрэв эхэлбэл дэлхий дахин хуучин шигээ амьдарч, ажиллах орчин нөхцөл үлдэх үү? Дэлхий дахин даяаршсан биш хуваагдсан шинжтэй цаашид хэр зэрэг удаан оршин тогтнох вэ? Дэлхий нийтийн тулгамдсан асуудлуудыг эсрэг тэсрэг хүчнүүд хамтран шийдэж чадах уу? гэх мэт олон асуудал тулгарч байна.

Эдийн засгийн хуулиуд нь хүмүүсийн санаа зоригоос үл хамааран үйлчилдэг объектив бодит шинж чанартай. Харин улс төр нь хүмүүсийн санаа бодол, үйл ажиллагаанаас шууд хамаардаг субъектив шинж чанартай юм. Ийм ч учир улс төр нь эдийн засгаас хамаардаг гэж сонгодог улс төрийн эдийн засгийн ухаан үздэг.

Гэтэл дайн байлдаан зэрэг онцгой нөхцөл байдал үүссэн үед улс төр тэргүүлэх үүрэгтэй болж, эдийн засаг, худалдааны харилцааг хүссэнээрээ өөрчилж болно гэдгийг Орос, Украины дайн эхэлсний дараах үйл явдал тодорхой харуулж байна. Барууны орнууд Оросын экспортод хориг тавьснаар дэлхий дахинд эрчим хүчний болон хоол хүнсний хямрал үүсэх нөхцөл бүрдлээ. Олон улсын худалдаа, эдийн засгийн харилцаа хэвийн явагдах боломжгүй боллоо. Тэгэхээр барууны хориг арга хэмжээ дайныг зогсоож, худалдаа, эдийн засгийн харилцааг эргээд хэвийн болгож чадах уу гэсэн асуулт гарч байна. Хэрэв ингэж чадахгүй бол уг хориг арга хэмжээний утга учир юунд байх вэ? Түүний улмаас олон сая хүн өлсгөлөн зовлонд нэрвэгдэх нь зөв үү? Улс төр анхдагч байх уу, эдийн засаг анхдагч уу? Энэ бүх асуудалд хариу олохын тулд шинэ улс төрийн эдийн засгийн ухаан, шинэ арга зүйг хөгжүүлэх шаардлага үүсэж байна.

#### **IV. Дүгнэлт**

Аж үйлдвэрийн IV хувьсгалын үр дүнд үүсэн хөгжиж буй шинэ эдийн засгийн бүрэлдэхүүн хэсгүүд хоорондоо нягт уялдаатай, харилцан хамааралтай юм. Шинэ эдийн засгийн гол эх сурвалж нь мэдлэгийн эдийн засаг бол үндсэн хөдөлгөгч хүч нь дижитал эдийн засаг юм. Харин ногоон эдийн засаг бол шинэ эдийн засгийн төвлөрсөн илэрхийлэл мөн. Эцсийн эцэст хүн төрөлхтөний ирээдүй гагцхүү ногоон эдийн засагтай холбоотой. Ногоон эдийн засгийг бүрдүүлэхийн тулд эргэлтийн эдийн засаг, бусадтай хуваалцах эдийн засгийг хөгжүүлэх ёстой. Эдгээр нь гагцхүү дижитал эдийн засгийн хөгжилд тулгуурлана. Энэ бүхнээс үзэхэд шинэ эдийн засгийг бүрдүүлэхийн тулд түүний бүрэлдэхүүн хэсгүүдийг цогцоор нь нарийн уялдаатай хөгжүүлэх хэрэгтэй.

Шинэ эдийн засаг нь хуучин эдийн засгийг халж, оюуны капитал болон орчин үеийн технологи, эрчим хүчний шинэ эх үүсвэр, шинэ материалд тулгуурлан дэлхийн эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлж, нийгмийн өөрчлөлтийг ихээхэн хурдасгах төлөвтэй байна. Гэхдээ энэ нь нийгмийн харилцааг хэрхэн өөрчлөх, хүн амын, ялангуяа ядүү зүдүү хэсгийн амьдралд ямар нөлөө үзүүлэх, хүн төрөлхтөний ирээдүйг яаж өөрчлөх, улс хоорондын харилцааг яаж өргөтгөх нь тодорхой бус байна. Тэгээд ч шинэ эдийн засаг хөгжихийн зэрэгцээ Орос-Украины дайны улмаас дэлхийн улс төр, эдийн засгийн нөхцөл байдал эрс өөрчлөгдлөө.

Ийм шинэ нөхцөлд улс хоорондын улс төр, эдийн засгийн харилцаа болон улс орны хөгжлийн асуудлыг нарийн судлах шаардлагатай байгаа бөгөөд үүнийг шинэ улс төрийн эдийн засгийн ухаан хийх боломжтой болохыг дээр дурдсан зүйлүүдээр үндэслэв. Шинэ улс төрийн эдийн засгийн ухаан нь сонгодог улс төрийн эдийн засгийн ухаан, макро эдийн засгийн онол болон улс төр судлалын зарим онол, урсгалын нийлбэр цогц юм гэж үзэж байна. Өөрөөр хэлбэл, шинэ улс төрийн эдийн засгийн ухаан нь сонгодог улс төрийн эдийн засгийн ухааныг орчин үеийн эдийн засгийн болон улс төр судлалын онол, урсгалуудаар баяжуулсан шинжлэх ухаан юм. Энэ нь орчин үеийн дэлхий нийтийн болон улс орны хөгжлийн асуудлыг улс төр, эдийн засгийн харилцан хамааралд нь судалдгаараа онцлог юм.

### Ашигласан материал

1. Rifkin J. The Third Industrial Revolution: How the internet, Green Electricity, and 3-D Printing are ushering in a Sustainable Era of Distributed Capitalism, [www.worldfinancialreview.com](http://www.worldfinancialreview.com)
2. Дорж Т. (2018). Менежмент (Сурах бичиг), МУИС Пресс. 373-374 дэх тал
3. Silicon Valley. [www.investopedia.com](http://www.investopedia.com)
4. Bukht R., Heeks R. (2017). Defining, Conceptualizing and Measuring the Digital Economy, Manchester Centre for Development Informatics Working Paper №68, p.3
5. The Digital Economy. [www.policy.bcs.org/archives](http://www.policy.bcs.org/archives)
6. The Digital Economy. [www.vsemirnyjbank.org/ru](http://www.vsemirnyjbank.org/ru)
7. Australia's Digital Economy: Future Directions, [www.oaic.gov.au/images/documents](http://www.oaic.gov.au/images/documents)
8. Института статистических исследований и экономики знаний. (2019). Что такое цифровая экономика? Тренды, компетенции, измерение, Москва, с.13
9. Баттөмөр Б. (2022). Төрийн зохицуулалт. Уб.,
10. Artificial Intelligence? [www.zdnet.com/article](http://www.zdnet.com/article)
11. Где больше всего роботов, [www.econs.online/articles](http://www.econs.online/articles)
12. Glasgow Climate Pact, article 20, [www.unfccc.int](http://www.unfccc.int)
13. What is Green Economy? [www.sociologygroup.com](http://www.sociologygroup.com)
14. Green Economy Roadmap. (2012). International Chamber of Commerce, p.10
15. Green Economy Roadmap. (2012). International Chamber of Commerce, p.11
16. Курс на зелёный рост, [www.oecd.org/greengrowth](http://www.oecd.org/greengrowth)
17. What is Sharing Economy? [www.investopedia.com](http://www.investopedia.com)
18. Монголын хамгийн анхны “Ус дахин боловсруулах үйлдвэр”-ийн бүтээн байгуулалтын ажил эхэллээ. [www.ikon.mn](http://www.ikon.mn), 25/08/2022
19. Glasgow Climate Pact, articles 25,26, 27, [www.unfccc.int](http://www.unfccc.int)
20. Батхишиг Б. (2020). Монгол дахь зах зээлийн эдийн засгийн хөгжлийн асуудлууд, Уб., 44-46 дахь тал
21. Батхишиг Б. (2020). Монгол дахь зах зээлийн эдийн засгийн хөгжлийн асуудлууд, Уб., 46 дахь тал
22. Почему экономическая наука бессильна?. (2009). [www.republic.ru](http://www.republic.ru)